

ЦӨМИЙН АЮУЛААС СЭРЭМЖИЛСЭН САНАЛ САНААЧИЛГУУД, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

С.Баясгалан¹

Дэлхийд цөмийн аюулаас сэрэмжилсэн олон санаачилгууд гарч байсан бөгөөд тэдгээрийн дотор цөмийн аюулаас сэрэмжлэх гол арга зам нь Цөмийн зэвсэггүй бүс (ЦЗБ) байгуулах явдал юм. Доктор Эл Барадэйн хэлсэнчлэн өнөөдөр цөмийн зэвсэггүй бүс дэлхийн улс орнуудын гуравны нэгийг хамарч, дэлхийн өмнөд хагасыг бараг бүхлээр нь бүрхээд байна. Ингэснээр ЦЗБ-үүд дэлхийг цөмийн зэвсгээс ангид байлгахад нэн тэргүүний чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ². Гэхдээ олон улсын харилцаанд үүсэж буй нөхцөл байдал, цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн улс төр, эдийн засгийн ашиг сонирхол зэргээс шалтгаалж цөмийн зэвсэггүй орон зай бий болгох зарим санал санаачилга тэр болгон биеллээ олоход амар байдаггүй. Өнөөгийн байдлаар дэлхийд хүн ам суурьшсан цөмийн зэвсэггүй 6 бүс байгаа нь Латин Америкийн, Африкийн, Зүүн Өмнөд Азийн, Өмнөд Номхон далайн, Төв Азийн, Монголын гэсэн ЦЗБ байгаа бөгөөд Монгол улсын ЦЗБ-ийн асуудал бүрэн баталгаажаагүй хэлэлцээний шатандаа явж байгаа билээ.

Цөмийн аюул гэдэгт зөвхөн цөмийн зэвсгийн асуудлыг ойлгох нь учир дутагдалтай, үүнд цөмийн хог хаягдал, цөмийн эрчим хүчний салбараас гарч буй хүн ам, байгаль орчинд цацрагийн хор нөлөө үзүүлэх элементүүд орно. Тиймээс ч ЦЗБ-ийн асуудал болон 1968 онд байгуулагдсан Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнд цөмийн зэвсэг гэлтгүй цацраг идэвхийн аюултай аливаа асуудлыг хөндсөн заалтууд ордог.

Үл дэлгэрүүлэх гэрээгээр дэлхий даяар цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй, ийм төрлийн зэвсэг байвал хорогдуулах асуудлыг авч үздэг бол ЦЗБ Үл дэлгэрүүлэх гэрээний зорилтыг бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг билээ. Үүгээр зогсохгүй ЦЗБ нь зэвсэг хорогдуулах, цөмийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх хэм хэмжээг бэхжүүлж, цөмийн зэвсгийг байрлуулах болон хэрэглэх боломжит орон зайг нь хязгаарлаж өгдөг³. Зарим тохиолдолд энэ нь зөвхөн цөмийн зэвсгээр хязгаарлагдахгүй. Энэ утгаараа Үл дэлгэрүүлэх гэрээ ЦЗБ-ийн үүргийг баталгаажуулж өгсөн байдаг ба Үл дэлгэрүүлэх гэрээний 7-р зүйлд “энэхүү гэрээнд туссан хязгаарлалт бүлэг улсын тухайн нутаг дэвсгэр дээр цөмийн зэвсэг байлгахгүй байх үүднээс бүс нутгийн гэрээ байгуулах эрхийг хөндөхгүй” гэж заасан

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш

² <http://www.iaea.org/newscenter/news/2007/tlatelolco.html>

³ http://cns.miis.edu/nwfs_clearinghouse/

байдгаас харагдана⁴.

Цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай 1999 оны НҮБ-ын Зэвсэг хураах комиссын илтгэлд цөмийн зэвсэгтэй улсууд “ЦЗБ-ийн гэрээг дагалдах протоколд орох замаар тухайн ЦЗБ-д харъяалагдах улс орнуудын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэх, хэрэглэхээр сүрдүүлэхгүй байх эрх зүйн үүрэг хүлээнэ” гэсэн байдаг⁵. Хамгийн анх цөмийн зэвсэгтэй улсууд Тлателолкийн гэрээний хоёр дахь нэмэлт протоколд нэгдсэнээр Латин Америкийн орнууд их гүрнүүдээс аюулгүй байдлын баталгаа авсан байдаг⁶. Гэхдээ зарим гэрээний заалтуудад цөмийн зэвсэгтэй улс орнуудын ашиг сонирхлыг хөндсөн зүйл заалт орсон байдаг учраас дагалдах протоколыг батлахыг яардаггүй. Тухайлбал АНУ Тлателолкоос бусад протоколд нэгдээгүй байгаа бол ОХУ зөвхөн Тлателолко, Раротонга, Пелиндабын протоколд нэгдсэн байх жишээтэй, гэтэл цаана нь гурван ЦЗБ протоколдоо ашиг сонирхол бүхий цөмийн зэвсэгтэй гүрнүүдийг оруулахыг хичээн ажилласаар байна. Цөмийн аюулаас сэрэмжилсэн хэрэгжиж буй санал санаачилгууд нь өнөөдөр албан ёсоор байгуулагдсан ЦЗБ-үүд болж байна.

Тлателолкийн гэрээ буюу Латин Америкийн ЦЗБ

1962 оны Карибын хямрал Латин Америкийн улс орнууд хүйтэн дайны үед хэрхэн хоёр их гүрний цөмийн зэвсгийн өрсөлдөөний талбар болох аюултайг тод харуулсан. Аль нэг талд нь орохгүй гэсэн байр суурьтай Латин Америкийн орнууд ЦЗБ байгуулах санал гаргаж, 1967 оны 2-р сарын 14-нд Мехико хотын ойролцоох Тлателолкод хуралдаж гэрээг баталсан ба 1969 оны 4 дүгээр сарын 25-нд хүчин төгөлдөр болж түүнээс хойш Латин Америкийн 33 улс нэгдэн ороод байна.

Нэмэлт I протоколоор Латин Америкийн нутаг дэвсгэрт олон улсын үүрэг хүлээдэг улсуудад цөмийн зэвсэггүй статус үйлчлэх үүргийг тодорхойлсон бөгөөд энэхүү протоколд Их Британи, АНУ, Нидерланд, Франц зэрэг улсууд гарын үсэг зурж, үүрэг авсан байдаг.

Нэмэлт II протоколоор Латин Америкийн цөмийн зэвсэггүй бүсийн статусыг хүндэтгэх үүргийг цөмийн зэвсэгтэй гүрнүүд хүлээсэн бөгөөд тухайн үеийн цөмийн зэвсэгтэй таван гүрэн гэрээг хүлээн зөвшөөрч протоколыг баталснаар Латин Америкийн цөмийн зэвсэггүй бүсийн ач холбогдлыг, олон улсын эрх зүйн чадамжийг өндөрт өргөсөн. Тэд Өмнөд Америкийн улсуудыг цөмийн зэвсгээр сүрдүүлэхгүй, тэдний эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх үүрэг хүлээсэн.

Раротонгийн гэрээ буюу Өмнөд Номхон далайн Цөмөөс ангид бүс

Улмаар Номхон далайд ЦЗБ байгуулах асуудал нь Франц Номхон далайд цөмийн туршилт хийснээс үүдэн гарч ирэв.

1985 оны 7 сарын 8-нд Номхон далайн өмнөд хэсэгт цөмийн зэвсэггүй бүс үүсгэх тухай Раротонгийн гэрээг 10 улс баталсан бөгөөд 1986 оны 12 сарын 11-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна. Энэхүү гэрээнд нэгдсэн улс орнууд бусад гэрээнд оролцогчдын нэгэн адил Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)-аас цөмийн зэвсэггүй улсын баталгаа олгосон. Гэрээнд дагалдах I протоколоор цөмийн зэвсэгтэй 4 гүрэн Номхон

⁴ http://cns.miis.edu/nwfs_clearinghouse/

⁵ <http://www.nti.org/treaties-and-regimes/proposed-internationally-legally-binding-negative-security-assurances/>

⁶ <http://www.nti.org/treaties-and-regimes/proposed-internationally-legally-binding-negative-security-assurances/>

далайн Өмнөд хэсгийн цөмөөс ангид бүсийн статусыг хүндэтгэхээ илэрхийлсэн. II протоколоор гэрээний заалтыг зөрчих дурын үйлдэл, тэр дундаа цөмөөс ангид бүс дотор, гэрээнд нэгдэгч талуудын эсрэг ердийн зэвсэг ашиглахгүй, хэрэглэхээр сүрдүүлэхгүй байх үүрэг хүлээсэн бол III протоколоор уг бүсийн хил дагуу цөмийн аливаа зэвсэг туршихгүй байх үүрэг хүлээсэн. Уг протоколуудаар цөмийн зэвсэгтэй гүрнүүд хамтарсан эрх зүйн баталгаа өгсөн бөгөөд цөмийн зэвсэгтэй таван гүрэн хамтарсан баталгаа гаргаж, үүрэг хүлээсэн байдаг.

Раротонгийн гэрээний цөмөөс ангид бүс хэмээх ойлголтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээний хувьд утга төгөлдөр болгосонд оршиж байгаа ба “цөмийн зэвсэг” бус “цөмийн аливаа цацраг ялгаруулах чадвар бүхий бодис” хэмээх ойлголтын хүрээнд авч үзсэнээр цөмөөс ангид байхыг өргөн утгаар авч хэрэглэн цөмийн зэвсгээс гадна цөмийн хог хаягдал байршуулахгүй байх, цөмийн туршилтыг хориглосон зэрэг олон шинэлэг талуудыг тусгасны зэрэгцээ уг бүс нутаг дэвсгэрт төдийгүй бүсийн хил дагуу цөмийн туршилт хийхийг хориглосон нь уг бүсийн статус, цөмийн зэвсгээс ангид байх чанарыг нь илүү баталгаатай болгосон юм.

Пелиндабагийн гэрээ буюу Африкийн ЦЗБ

Франц улс Африкийн Сахарт цөмийн туршилт хийснээс 1960 онд Африкт ЦЗБ байгуулах асуудал яригдаж эхэлсэн байна. Жилийн дараа Африкт аливаа цөмийн туршилт хийх, тус тивийг туршилтын талбай, цөмийн зэвсэг хадгалах болон дамжин өнгөрүүлэхээр ашиглуулахгүй байхыг уриалж НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1961 оны 11-р сарын 24-нд баталсан Африкийн ЦЗБ-ийн талаар 1652 тогтоолыг хүндэтгэн үзэхийг уриалсан байна.⁷

Бүр 1965 оноос хоёр тулгуур зарчим болох бүх улс орнууд Африкийн ЦЗБ-ийг хүндэтгэн үзэх, мөн Африкийн ЦЗБ-ийг тунхаглах зэрэг нь яригдсаар ирсэн.

1990-ээд оны эхээр ӨАБНУ дахь аппартеид дэглэм унаж, “хүйтэн дайн” төгсгөл болсон, олон улсын харилцаан дахь даяаршил, интеграцлал идэвхижсэн зэрэг олон хүчин зүйлс эл бүс нутгийг цөмийн зэвсгээс ангид орчин болоход эергээр нөлөөлсөн. 1996 онд Африкийн орнууд цөмийн зэвсэггүй бүсийн тухай Пелиндабагийн гэрээг байгуулснаар Африк нь цөмийн зэвсгээс ангид анхны тив болсон. Удалгүй НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 50-р чуулганаар Африк тивийг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай гэрээг дэмжин сайшаасан бөгөөд эл бүсийн статусыг дэмжин хүндэтгэхийг цөмийн зэвсэгтэй гүрнүүдэд уриалсан юм.⁸

Пелиндабагийн гэрээ нь цөмийн зэвсэггүй бүс үүсгэх тухай гэрээг илүү төгөлдөржүүлж чадсан гэж үзэж болно. Энд тухайлбал, цөмийн зэвсэггүй бүс үүсгэх нь үл дэлгэрүүлэх бодлогын нэг чухал нөхцөл болохыг онцлохын хамт үл дэлгэрүүлэх бодлогыг дэмжих зарчмын хүрээнд Олон улсын атомын энергийн агентлагтай харилцах харилцааг олонтоо онцолсон байна. Мөн цөмийн эрчим хүчийг энхийн зориулалтаар ашиглах үндсэн зарчмуудыг тусгайлан нарийн томъёолсноороо ач холбогдолтой юм.⁹

⁷ Resolution 1652, November 24, 1961

⁸ Хосбаяр, Дүгэрсүрэн. Олон улсын эрх зүй. УБ. 1998, 263-р тал

⁹ African Nuclear Weapon-Free Zone Treaty (Pelindaba Treaty) (Reproduced from UN General Assembly document A/50/426), Article 8,9

Пелиндабагийн гэрээг тус тивийн дор хаяж 28 улс соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох учиртай боловч гэрээнд гарын үсэг зурсан 50 улсаас одоогийн байдлаар 19 нь гэрээг соёрхон баталсан, 28 нь гэрээг соёрхон батлах явцдаа байна¹⁰. Цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс Хятад, Франц, Их Британи гэрээний нэмэлт II протоколыг баталсан. Гэвч АНУ, ОХУ гарын үсэг зурсан ч соёрхон батлаагүй байгаа нь цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн хамтарсан баталгааг сул болгож байгаа билээ.

Цөмийн зэвсэггүй бүсэд багтах улс орнуудыг цөмийн эрчим хүчийг энхийн зориулалтаар ашиглахыг зөвшөөрдөг боловч аюулгүй байдлын маш хатуу нөхцлийг шаарддаг бөгөөд одоогийн байдлаар Африкийн аль ч улс энэ нөхцлийг гүйцэлдүүлэх боломжгүй байна. Пелиндабагийн гэрээг соёрхон батлах явц удаашралтай байгаа нь АНУ, ОХУ нэмэлт II протоколд нэгдэхгүй байгаагаар холбоотой юм.

Бангкокийн гэрээ буюу Зүүн Өмнөд Азийн ЦЗБ

1995 оны 12 сард АСЕАН-ы гишүүн орнууд Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны ээлжит чуулганаар энэ бүс нутгийг цөмийн зэвсгээс ангид байлгах эрмэлзлийн дор цөмийн зэвсэггүй бүс үүсгэсэн тухай Бангкокийн гэрээг байгуулсан юм.¹¹

Бангкокийн гэрээгээр АСЕАН-ы гишүүн орнууд 1968 оны Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ болон АСЕАН-ы үндсэн зарчмын хүрээнд ЗӨА-ийн нутаг дэвсгэр дээр аливаа төрлийн цөмийн зэвсэг байрлуулах, цөмийн туршилт хийх, цөмийн хог хаягдал булшлахыг хориглосон байна. Өмнө нь байгуулагдаж байсан ЦЗБ-үүдийн нэгэн адил заалтууд Бангкокийн гэрээнд орсон байдаг ба эдгээрийг хянахад Олон улсын атомын энергийн агентлагтай нягт хамтран ажиллах талаар гэрээнд тодорхой заасан байдаг. Хэдийгээр гэрээг байгуулсны дараа жилийн дотор 1997 оноос Бангкокийн гэрээнд тус бүс нутгийн орнууд нэгдэн орсон боловч гэрээнд цөмийн зэвсэгтэй нэг ч улс нэгдэн гарын үсэг зураагүй нь тус бүс нутаг дахь их гүрнүүдийн ашиг сонирхолд уг гэрээ нийцэхгүй байгааг харуулж байгаа юм.

Бангкокийн гэрээний протоколд цөмийн зэвсэгтэй гүрнүүд гарын үсэг зурахаас татгалзсан үндсэн шалтгаан нь уг гэрээний зарим нэр томъёоны тодруулгын асуудал байгаа бөгөөд 1997 оны 10 сараас хойш өнөөдрийг хүртлэх хугацаанд тухайн бүсийн нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тодорхойлох асуудлаар санал зөрөлдсөөр байгаад оршино. Өөрөөр хэлбэл, их гүрнүүд өөрийн ашиг сонирхлын үүднээс ЗӨА-ийн бүс нутгийг геополитик, геозэдийн засгийн өндөр ач холбогдолтой гэж үзэж байгаа тул тус бүс нутагт цөмийн аливаа байгууламж барих, дамжин өнгөрүүлэх гол зангилаа болж байгаа юм. Иймээс уг бүс нутаг их гүрнүүд, тэр дундаа цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн хувьд эдийн засгийн төдийгүй цэрэг-стратегийн өндөр ач холбогдолтой юм.

Цөмийн зэвсэгтэй гүрнүүд нэмэлт протоколд нэгдээгүйг эс тооцвол өнөөдрийн байдлаар Филиппинээс бусад бүх 9 улс Бангкокийн гэрээг соёрхон батлаад байгаа бөгөөд энэ улсын хувьд Хятадтай Спратлийн бүлэг арлаас үүдэлтэй газар нутгийн маргаантай байгаа нь гэрээг батлахгүй байх нэгэн шалтгаан болж байгаа юм.

¹⁰ Adam Shapiro. Nuclear-Weapon-Free Zones. The Solution to Nuclear Disarmament? http://www.un.org/Pubs/chronicle/2004/webArticles/081204_nwz.asp

¹¹ Хосбаяр, Дүгэрсүрэн. Олон улсын эрх зүй. УБ. 1998, 262-р тал

Төв Азийн цөмийн зэвсэггүй бүс.

1991 онд ЗХУ задарснаар Төв Азид Казахстан, Узбекистан, Таджикистан, Туркменистан, Кыргызстан гэсэн таван улс тусгаар тогтнолоо зарласан. Үүнээс хойш бүх улсууд цөмийн зэвсэггүй бүс болохыг эрмэлзсэн. 1992 онд Монгол улс цөмийн зэвсэггүй статусаа зарласны дараа 1993 онд Узбекистаны ерөнхийлөгч Ислам Каримов НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дахь хуралдаан дээр гаргасан¹².

1997 оны 2 сарын 28-нд таван улсын төрийн тэргүүн нар Төв Азийн цөмийн зэвсэггүй бүс байгуулах Алма-Атагийн тунхаглал гаргаснаар эл бүс нутгийг цөмийн зэвсгээс ангид байлгах тухай бодит үйл явц эхлэхэд нөлөөлсөн¹³.

Алматын тунхаглал дээр үндэслэн 1997 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар дээрх таван улс “Төв Азид цөмийн зэвсэггүй бүс байгуулах” тухай тогтоол оруулсныг санал хэлэлцэлгүй 52/35S тогтоол гарган баталсан байдаг.

1997 оны 9 сард таван улсын гадаад хэргийн сайд нар Ташкентад хамтарсан мэдэгдэл хийж, Төв Азид цөмийн зэвсэггүй бүс байгуулах ажилд НҮБ-тай нягт хамтран ажиллахаар тохиролцсон.

Уг ажлын үр дүнд 2002 оны 9 сарын 27-нд Төв Азид цөмийн зэвсэггүй бүс байгуулах Самаркандын гэрээг байгуулж, 2006 оны 9 сарын 8-нд Семипалатинскт гарын үсэг зурснаар цөмийн зэвсэггүй бүсийн тоо ахин нэгээр нэмэгдэж, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх бодлогод чухал нэмэлт болсон билээ¹⁴.

Төв болон Дорнод Европын ЦЗБ байгуулах санаачилга

Дээр дурьдсан амжилттай хэрэгжсэн ЦЗБ-үүдээс гадна цөмийн зэвсгээс ангид байх санал, санаачилгууд тэр болгон биеллээ олж чадаагүй тохиолдлууд байдаг.

Цөмийн зэвсгээс ангид байх санал нь хэрэгжиж амжаагүй байгаагийн нэг нь Төв болон Дорнод Европт ЦЗБ байгуулах санаачилга юм. 1950 оноос хойш Төв болон Дорнод Европт ЦЗБ байгуулах санаачилга олон удаа гарч байсан боловч тэр бүр амжилттай болж чадаагүй өнөөг хүрсэн. Хүйтэн дайны үед гарч байсан ийм нэг санаачилга нь Польшийн гадаад хэргийн сайд Рапакийн төлөвлөгөө юм. Тэрээр 1957 онд Европт Польш, Чехословак, Баруун, Зүүн Германыг хамруулсан цөмийн зэвсгээс ангид бүс байгуулах санаачлага гаргасан боловч барууны холбоотнуудын зүгээс дэмжлэг аваагүй. Хүйтэн дайн дууссаны дараа 1990 онд болсон НҮБ-ын ЕА-н чуулганаар Беларусь улс Балтын тэнгисээс Хар тэнгис хүртлэх газрыг буюу хуучин Варшавын гэрээний гишүүн орнууд ЦЗБ болгох саналыг дахин сэргээж тавив. Гэвч эдгээр орнууд нь НАТО-ийн дорно зүг тэлэлттэй зөрчилдөж байсан учраас Беларусийн санал үр дүнд хүрээгүй. 1995 онд Беларусь энэ саналаа Үл дэлгэрүүлэх гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх бага хуралд дахин тавьсан боловч амжилт олоогүй. ОХУ болон Украин улсууд Төв болон Дорнод Европт ЦЗБ байгуулах саналыг дэмжиж байсан ч АНУ, Их Британи, Франц улсууд хурцаар шүүмжилж байсан юм¹⁵.

¹² Мөн тэнд

¹³ “Text of Almaty Declaration on Aral Sea Pollution,” *Народное слово*(Tashkent), March 4, 1997, in FBIS Document FTS19970530002474.

¹⁴ Scott Parrish, *Central Asian States Achieve Breakthrough on Nuclear Weapon-Free Zone Treaty*. Sep. 2006. <http://cns.miis.edu>

¹⁵ http://www.fas.org/programs/ssp/nukes/ArmsControl_NEW/nonproliferation/NFZ/NP-NFZ-CE.html

Өмнөд Азид цөмийн зэвсэггүй бүс үүсгэх санаачлага, үйл явц

Өмнөд Азид БНХАУ, Энэтхэг хоёрын хооронд харилцаа муудсан нь Энэтхэгийг цөмийн зэвсэгтэй болгох гол шалтгаан болсон. Үүний дараа 1972 онд НҮБ-ын Цөмийн эрчим хүчний XVI бага хурлаар Пакистан улс нь Өмнөд Азид Тлателолкогийн гэрээний загвараар цөмийн зэвсэггүй бүс байгуулах санаачлага гаргасан.

1974 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 29-р чуулганаар Өмнөд Азийн Балбын Вант улс, Бангладеш, Бутан, Шри-ланка, Мальдив, Пакистан, Энэтхэг 7 улсын газар нутгийг хамарсан цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай дээрх санаачлагыг авч хэлэлцээд дэмжсэн байдаг. Дараа нь 1975, 1981-1982 онуудад тус тус НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар ахин хэлэлцсэн. 1985 оны 2 сард Өмнөд Азийн цөмийн зэвсэггүй бүс байгуулах асуудлаар санал хураахад Энэтхэг “бодит бус, үзүүлэх тоглолт” гэж шүүмжилж байв¹⁶.

Гэвч зарим судлаачдын бичсэнээр Энэтхэгийн “энхийн зорилготой цөмийн хөтөлбөр” болон Пакистаны “цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай энх тайванч санаачлага” нь тус тусын цөмийн зэвсэг эзэмших гэсэн ашиг сонирхлоо нуун далдалсан улс төрийн алхмууд байсан гэсэн саналыг ч үгүйсгэхгүй байна.¹⁷

1990 оноос хойш Балбад ардчилсан хөдөлгөөн өрнөсөн нь энэ улсын энх тайванч гадаад бодлого тунхаглахад нөлөөлсөн. Мөн онд Балбын ван Бирендра Балбыг энхтайвны бүс болгон зарлах тухай санал дэвшүүлсэн боловч Энэтхэгийн тал дэмжээгүй¹⁸. Дэмжихгүй байх шалтгаанаа өөрийн аюулгүй байдлын хилийг Балба-Хятадын хилээр өнгөрдөг гэж үзсэнээс тухайн санал Энэтхэгийн аюулгүй байдлын стратегид харшилж байна гэж үзсэн. Нэг зэрэг цөмийн зэвсэггүй бүс байгуулах асуудал дээр зарим нэг нааштай хандлага гарч байсан юм. Тухайлбал, 1991 онд Энэтхэг, Пакистан, Орос, Хятад, АНУ гэсэн таван улсын бүс нутгийг цөмийн зэвсгээс ангид байлгах тухай хэлэлцээ хийсэн байдаг.

1998 онд Энэтхэг, Пакистан улсууд бие биенийгээ давах гэсэн мэт цөмийн зэвсгийн туршилтууд ойр ойрхон хийсэн нь Өмнөд Азид цөмийн зэвсэггүй бүс байгуулах үйл явцыг зогсонги байдалд оруулсан.

1971 оны 12 сарын 16-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 26 дахь чуулганаар Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгон зарлах тухай 2832 (XXVI) тогтоол баталсан¹⁹. Үүний дараа 1972 онд энэ асуудлыг боловсруулах хороо байгуулагдаж байсан. Тогтоолын гол зорилго нь тухайн үед буюу 1970 онд оршиж байсан их гүрнүүдийн өрсөлдөөнөөс Энэтхэгийн далайг ангижруулахад оршиж байв. АНУ, Их Британи, Франц зэрэг улсууд уг тогтоолыг эсэргүүцэж байснаас хэрэгжих боломжгүй болсон билээ²⁰. Дөнгөж сая Шри-Ланкийн засгийн газар их гүрнүүдийн дургүйцлийг үл харгалзан Энэтхэгийн далайн орчмыг энх тайвны бүс болгох шинэ арга замуудыг хайхаа мэдэгдсэн. Шри-Ланкийн гадаад хэргийн сайд Дю Гунасекера Шри-Ланка энэхүү санаачилгыг 70 жилийн өмнө гаргаж байсан боловч АНУ, Их Британи, Франц зэрэг орнууд дургүйцсэн гэж байв.

¹⁶ Savita Pande. Nuclear Weapon Free Zone in South Asia. <http://www.cia.net.org/olj>

¹⁷ Pande. Nuclear Weapon Free Zone in South Asia. <http://www.cia.net.org/olj>

¹⁸ БНЭУ-ын гадаад бодлогын тухай мчлах. ГХЯ. Нэгдүгээр газар. 1997

¹⁹ <http://www.asianewsnet.net/home/news.php?sec=1&id=28853>

²⁰ <http://www.asianewsnet.net/home/news.php?sec=1&id=28853>

Ойрхи Дорнодод цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай санаачилга

Ойрхи Дорнодод дэгдсэн 1948, 1956, 1967, 1973 онуудын дайны дараа Израиль өөрийн цөмийн зэвсэгтэй болж аюулгүй байдалдаа хангалттай баталгаатай болохоор идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн²¹ бөгөөд Израиль өнөөдрийг хүртэл Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээнд нэгдэн ороогүй хуруу дарах цөөхөн орны нэг бөгөөд өөрийн “цөмийн зэвсгийг туршихгүй, цөмийн зэвсэгтэйгээ тунхаглахгүй, цөмийн зэвсгээ нотлохгүй” гэсэн байр суурийг баримталдаг.

Египет 1974 онд Иран улсын хамт цөмийн зэвсэггүй бүс байгуулах анхны санаачлагыг гаргасан байдаг. 1974 оноос хойш Ойрхи дорнодод цөмийн зэвсэггүй бүс байгуулах асуудлаар Египет тэргүүтэй Арабын зарим орон НҮБ-тай идэвхтэй хамтран ажиллаж ирсэн бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас энэ талаар хэд хэдэн тогтоолыг гаргаж байсан.²² 1990 онд Египетийн ерөнхийлөгч Мубарак Ойрхи Дорнодод бүх төрлийн үй олноор хөнөөх зэвсэггүй бүс байгуулах санаачлагыг гаргасан²³. Түүний санаачлага олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгийг анхнаасаа хүртсэн бөгөөд 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дахь чуулганаас А/53/74 тоот тогтоолыг баталж²⁴, 1999 онд хуралдсан Олон улсын атомын энергийн агентлагийн Ерөнхий хуралдаанаас Ойрхи дорнодод цөмийн зэвсэггүй бүс байгуулах нь тус бүс нутагт тогтвортой байдал, энх тайвныг тогтоох чухал арга хэмжээ болно гэж үзэн санаачлагыг дэмжсэн бөгөөд 23 тоот тогтоолыг баталсан байдаг.²⁵ 2003 оны 12 сарын 19-нд Ойрхи Дорнодод цөмийн зэвсэггүй бүс байгуулах гэрээг боловсруулахаар үндсэндээ тогтоод байна.²⁶

Зүүн хойд Азийн цөмийн зэвсэггүй бүс үүсгэх санаачлага, үйл явц

Хэдийгээр ХХ зууны II хагасаас ЗХА-ийн цөмийн зэвсэггүй улсуудын Холбоо байгуулах асуудал яригдсаар ирсэн боловч өнөөдрийг хүртэлх урт хугацаанд ирсэн боловч тус бүс нутагт цөмийн зэвсэггүй бүс байгуулж чадахгүй байна. “Хүйтэн дайн”-ы үед БНХАУ, БНАСАУ-ын гаргаж байсан мэдэгдэл, Умард Солонгосын цөмийн хөтөлбөр хэрэгжихээс өмнөх Хоёр Солонгосын хамтарсан тунхаглал зэрэг цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай нэлээд хэдэн албан ёсны санаачлага гарч байсан хэдий ч энэ бүс нутгийн оролцогчид болох Хятад, ОХУ, АНУ нь цөмийн их хэмжээний зэвсэгтэй, үлдсэн хоёр оролцогч болох Япон, БНСУ нь Америкийн “цөмийн шүхэр” доор аюулгүй байдлаа хамгаалдаг, Монгол нь цөмийн зэвсэгтэй хоёр гүрний дунд жийргэвчийн үүрэг гүйцэтгэж ирсэн, Умард Солонгос нь өөрийн цөмийн зэвсэгтэй болохоор аль 1970-аад оноос чармайж ирсэн зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй.

Умард Солонгос цөмийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой 1995 оноос тус бүсэд цөмийн зэвсэггүй бүс байгуулах санаачилга албан бус шугамаар идэвхтэй өрнөж

²¹ Rebecca Stevens and Amin Tarzi. *Egypt and the Middle East Resolution at the NPT 2000 Review Conference*

²² Rebecca Stevens and Amin Tarzi. *Egypt and the Middle East Resolution at the NPT 2000 Review Conference*

²³ *Establishment of a NWfZ in the region of the Middle East. Programme for Promoting Nuclear Non-Proliferation. Briefing Book. Vol. II. Treaties, Agreements and Other relevant Documents. (7th Ed.). F-28*

²⁴ *Establishment of a NWfZ in the region of the Middle East. Programme for Promoting Nuclear Non-Proliferation. Briefing Book. Vol. II. Treaties, Agreements and Other relevant Documents. (7th Ed.). F-28*

²⁵ <http://www.iaea.org/GC/gc43/resolutions/gc43res23.html>

²⁶ Adam Shapiro. *NWfZ. The solution to Nuclear Disarmament*

эхэлсэн бөгөөд цөмийн зэвсэгтэй улсуудын болон цөмийн зэвсэггүй улсуудын аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцсэн шийдлийг олох онол, судалгааны эрэл хайгуул өнөөдөр ч идэвхитэй хийгдсээр байна.

“Хүйтэн дайн” төгсгөл болсоноор улс төрийн уур амьсгалын дулаарал БНАСАУ болон БНСУ-ын харилцаа сайжирахад нөлөөлсөн юм. Хоёр тал үндэстнээ нэгтгэх болон хойгийн аюулгүй байдлын асуудал зэрэг олон асуудлаар нааштай байр суурьт хүрч эхэлсэн. Үүний нэг нь 1991 оны 12 сарын Умард ба Өмнөд Солонгосын Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгах тухай Хамтарсан тунхаглал билээ.

1994 онд БНАСАУ АНУ-тай Хойд Солонгосын цөмийн эрчим хүчийг хөгжүүлэхэд олон талын хариуцлага хүлээх асуудлыг багтаасан цөмийн зэвсэгт хяналт тавих тухай гэрээ буюу хоёр талын Тулгуур хэлэлцээрийг байгуулсан байдаг²⁷. Уг хэлэлцээрээр талууд дөрвөн үндсэн чиглэлээр хамтарч ажиллахаар тогтсоны дотор Цөмийн зэвсэггүй Солонгосын хойгт энх тайван, аюулгүй орчныг бүрдүүлэх, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх олон улсын дэглэмийг бэхжүүлэх асуудлыг тусгасан байв. 2001 онд зарласан Ж.Бушийн засгийн газрын бодлого ч Умардын талаарх Америкийн байр суурийг залгамжилсан билээ. Түүний 2002 оны мэдэгдэлд Умардын талаарх байр суурь улам хурцдаж, “нүглийн тэнхлэг”-т оруулж, Америкийн зүгээс болзошгүй цөмийн цохилт хийж болох 7 орны тоонд БНАСАУ-ыг багтаасан²⁸. АНУ-ын ерөнхийлөгч Ж.Бушийн засаг захиргааны эрс хатуу байр суурь нь 1994 оны хэлэлцээрийг байгуулж чадсан ерөнхийлөгч Б.Клинтоны бодлогоос эрс ялгарч байсан төдийгүй илт сүрээр далайлгасан шинжтэй байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Гэвч Америкийн талын дээрх бүх мэдэгдэл, байр суурь үндэслэлтэй байсан бөгөөд БНАСАУ нь үнэхээр АНУ-тай 1994 оны хэлэлцээрийг хэрэгжүүлэхээр болон Олон улсын атомын энергийн агентлагтай байгуулсан гэрээний дагуу бодит байдал дээр хамтарч ажиллахгүй байсан. Үүнийг Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийг тойрсон хоёрдахь хямрал дэгдсэний дараахан Жон Эндикот маш зөв ажиглан дүгнэсэн байдаг. Гэвч 2007 оны 3 сараас Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийг зогсоох тухай зургаан талт хэлэлцээнд ахиц гарч, цөмийн хөтөлбөрийг тойрсон асуудалд нааштай эерэг өөрчлөлтүүд гарах боломж нээгдсэн нь ЗХА-д цөмийн зэвсэггүй бүс үүсгэх явцыг дахин сэргээж хэрэгжүүлнэ гэдэг найдлагыг төрүүлж байсан. Харамсалтай нь Хойд Солонгос 2006, 2009 онд тус тус цөмийн туршилт хийв.

Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын санаачилга

1990 оноос өмнө манай улсад Зөвлөлтийн цэрэг байрлаж Монгол улсын аюулгүй байдлыг хамгаалах баталгаа болж байв. Харин Зөвлөлтийн цэрэг Монголоос гарсны дараа Монгол улс цаашид үндэсний аюулгүй байдлаа ямар арга замаар, хэрхэн хангах вэ гэсэн асуудал гарч ирсэн. Зөвлөлтийн цэрэг Монголоос гарсны дараа Монгол өөрийгөө ЦЗБ болгон зарлах нь аюулгүй байдлын баталгаа болох байв. Ингээд 1992 оны 9-р сарын 25-нд болсон НҮБ-ын Ерөнхий ассамблейн 45-р чуулган дээр Ерөнхийлөгч П.Очирбат үг хэлж,

²⁷ А.Түвшинтөгс. БНАСАУ-ын цөмийн хөтөлбөр ба ЗХА-ийн аюулгүй байдал. // “Стратеги судлал” 2003. №1, 58-р тал

²⁸ А.Түвшинтөгс. БНАСАУ-ын цөмийн хөтөлбөр ба ЗХА-ийн аюулгүй байдал. // “Стратеги судлал” 2003. №1, 70-71-р тал

Монгол улс цөмийн зэвсэггүй бүс болсныг зарласан. Монгол улсын энэхүү алхам нь 1968 оны Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ, 1974 оны 12-р сарын 9-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан 3261 F тогтоолын дагуу нэг улс дангаараа цөмийн зэвсэггүй бүс болох алхам болсон. Уг тогтоолд “ЦЗБ байгуулахтай холбогдсон үүрэг бүлэг улсууд, түүн дотроо газар зүйн том бүс нутгууд, нэг тивийг төдийгүй цөөн тооны улсууд тэр ч бүү хэл нэг улсыг ч хамарч болно” гэсэн заалтын дагуу 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас A/RES/53/77 “Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй бүсийн статус” хэмээх Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжих тухай тогтоол гаргасан юм. Уг тогтоолд “Монгол улс газар зүйн хувьд өвөрмөц байрлалтай, далайд гарцгүй орон. Тиймээс нутаг дэвсгэрийнх нь бүрэн бүтэн, хилийн халдашгүй дархан байдал, эдийн засаг, экологийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал их чухал тул цөмийн зэвсэггүй статусыг нь дэмжиж байна” гэж дурьдсан байдаг. НҮБ-ын Ерөнхий Ассамблейг Монголын бодлого, санаачилгыг дэмжин хүлээн авч гишүүн бүх улс орнуудыг ЦЗБ байгуулах, түүний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хамтран ажиллахыг уриалсан. Ингэснээр НҮБ-ын Ерөнхий Ассамблей “тус бүс нутаг дахь энхийн, нөхөрсөг, харилцан ашигтай харилцааг хөгжүүлэхэд оруулж буй Монголын идэвхтэй, эерэг оролцоог” дэмжиж байгаагаа илэрхийлж, энэ нь аюулгүй, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд өндөр хувь нэмэртэй болохыг илэрхийлсэн.

2000 оны 2 сарын 3-нд Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль, түүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай УИХ-ын 19 тоот тогтоолыг баталсан. Уг хууль нь Монгол улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, бусад аргаар олж авах, эзэмших, байрлуулах, аливаа хэрэгслээр тээвэрлэх, туршилт хийх, цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах, устгахыг хориглосон²⁹.

2000 оны Монгол улсын цөмийн зэвсгээс ангид хуультай танилцсаны дагуу Ерөнхий Ассамблейн 55 дахь чуулганаас A/55/56/S/2000/160 тогтоолыг баталсан³⁰. Мөн онд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн их гүрнүүд Монголын ЦЗБ статусыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Цөмийн зэвсэггүй бүсээ хөрш хоёр орноороо баталгаажуулах дараагийн алхам нь 2001 онд цөмийн зэвсэгтэй таван гүрэн Монгол болон НҮБ-ын шинжээчид Саппород уулзаж, манай улсын цөмийн зэвсэггүй статусыг цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргасан. Сүүлийн үед доктор Ж.Энхсайханы хичээл зүтгэлээр Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусын талаар тодорхой ахиц гарч байна. Тухайлбал 2012 оны 8 сарын 23-нд Монголын төлөөлөгчид Женев дахь цөмийн зэвсэгтэй таван гүрний төлөөлөгчидтэй уулзаж, цөмийн зэвсгээс ангид Монгол улсын статусыг олон улсын хэмжээнд цаашид баталгаажуулах асуудлаар санал бодлоо солилцсон байна. Уулзалтын үеэр цөмийн зэвсэгтэй 5 гүрний байнгын төлөөлөгчид уг асуудлаар хамтран гаргаж болох тунхаглалын төслийг Монголын төлөөлөгчдөд танилцуулж, түүнийг гаргахтай холбогдуулан ойрын үед хийж болох асуудлын талаар ярилцаж, хариу өгөхөө мэдэгдсэн байна.³¹

²⁹ Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль. УБ.2000

³⁰ <http://www.opanal.org/NWFZ/Mongolia>

³¹ http://www.embassymon.at/news/news_mon_108.html

Улс орноо цөмийн зэвсэггүй бүс болгосноороо бид хөрш орнуудыг хамарсан цөмийн аливаа маргаанд оролцохгүй, төвийг сахих бодлогоо хөрш зэргэлдээ болон бусад улс орноор хүлээн зөвшөөрүүлж, тэднээс энэ талаар баталгаа авах боломжтой юм³². Манай хоёр хөрш Монгол улсын хилийн ойролцоо удаа дараагийн цөмийн туршилтууд явуулж байсан нь саяхан. Дэлхийд ойролцоогоор 2036 удаагийн цөмийн туршилт хийгдээд байгаагаас 760 нь буюу бүх туршилтын 27 хувь нь хоёр хөрш улс Монголын хилийн ойролцоо хийсэн байгаа статистик үзүүлэлт нь Монгол улс өөрийгөө ЦЗБ бүс гэж зарлахын зэрэгцээ бусад ЦЗБ-үүдийн нэгэн адил цөмийн зэвсэгтэй их гүрнүүдээр, нэн ялангуяа хоёр хөрш орноороо баталгаа гаргуулж гурван талт гэрээ байгуулах нь нэн чухал болохыг харуулж байгаа юм. Хамгийн ойр нь гэхэд 1949-1989 оны хооронд өнөөгийн Казахстаны Семипалатинскийн талбайд 460 орчим цөмийн туршилт явуулсан байдаг³³ ба Хятад улс Шинжан Уйгурын Лоб нуурт 45 удаагийн туршилт хийсэн ба сүүлийн туршилтыг 1996 онд хийсэн³⁴. Өнөөдөр манай хилийн ойролцоо Орос, Хятадын 20 гаруй цөмийн объект байдгийн дотор цөмийн цахилгаан станцын нэн хортой шаар хаягдлын агуулахууд байдаг ба 10000 жил хор хөнөөл нь арилахгүй эдгээр хаягдлыг үүрд булшлах газрыг ч манай нутгийн ойролцоо барихаар төлөвлөж байгааг бид сонин хэвлэлээс уншиж мэдэж байна. Тухайлбал Хятад улс цөмийн хамгийн хортой хаягдлаа манайтай хиллэдэг Ганьсу мужийн Бэйшан гэгч газар байнга булшлахаар төлөвлөж байна. Энэ агуулахыг нэгэнт барьж ашиглалтад оруулчихвал ойрын 100-200 жилд өөр агуулах барих шаардлагагүй болох ажээ. Манай хойд хөршийн хувьд гэвэл цөмийн шаар хаягдлынхаа үлэмж хэсгийг Красноярскийн ойролцоо хадгалж байгаагийн дээр бусад улсын цөмийн шаар хаягдлыг тодорхой үнэ хөлсөөр авч хадгалах тухай хууль гаргаад хэрэгжүүлж байна³⁵. Мөн 2006 оны 1 сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин ураныг баяжуулах олон улсын төвийг манай ойролцоо байдаг Ангарск-д байгуулсан байдаг. Баяжуулсан уранаар дэлхийн эрэлт хэрэгцээг хангах зорилго бүхий энэ төв нэгэнт ашиглагдсан цөмийн шаар хаягдлыг хаана булшлах нь тодорхойгүй³⁶ зэрэг олон асуудлууд байна. Эдгээрээс үүдэн цацраг идэвхт бодис манай орны хилийг даван орж ирсэн байхыг үгүйсгэх аргагүй ба энэ тохиолдолд хүн амын эрүүл мэнд, тухайн газрын экологийн нөхцөл байдалд муугаар нөлөөлөх юм.

ЦЗБ гэхээр дан ганц цөмийн зэвсгийн асуудал гэж ойлгож болохгүй. Үүнд хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хор хохирол учруулахуйц цөмийн цацраг идэвхт бодисын хадгалалт, хамгаалалтын асуудал ч гэсэн хамаатай байдаг. Хэдийгээр Монгол улс ЦЗБ-ийн статустай хэмээн зарласан ч цөмийн аюулын асуудал хэвээр байгаа билээ. Сүүлийн үед Монголд цөмийн хог хаягдал байрлуулна, цахилгаан станц барина гэх мэт асуудлууд мэр сэр яригдаж шуугиан дэгдээсэн. Үүнээс үзэхэд гадаадын улс орнууд Монголын нутаг дэвсгэрийг цөмийн хог хаягдал булшлахад тохиромжтой газар гэж үзэхийн зэрэгцээ зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонсоход цөмийн цахилгаан станц үнэгүй барьж өгсөний хариуд цөмийн хог хаягдал булшлах санаанууд ч байгаа юм шиг дуулдаг байна. Нэгэнт

³² *Цөмийн зэвсэггүй статусын тухайд*, УБ, 2008

³³ <http://www-ns.iaea.org/appraisals/semipalatinsk.asp>

³⁴ <http://www.nti.org/facilities/710/>

³⁵ *Цөмийн зэвсэггүй статусын тухайд*, УБ, 2008

³⁶ *Цөмийн зэвсэггүй статусын тухайд*, УБ, 2008

Монгол улс цөмийн зэвсэггүй бүс хэмжээн олон улсад өөрийгөө зарласнаас гадна үүнтэй холбогдуулан баталсан "Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль", "Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль", "Цөмийн энергийн тухай" Монгол улсын хууль тогтоомж, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 184 тоот зарлигт Монгол улсын нутаг дэвсгэр дээр цөмийн хог хаягдлыг хадгалах, түр байршуулах, булшлах зорилгоор импортлох, хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа явуулахыг хориглосон заалтууд байдаг³⁷ нь Монгол улсад цацраг идэвхит аливаа бодисыг хадгалах, булшлах асуудал байхгүй, булшлах асуудал нь байгаль орчны хувьд хортой төдийгүй хоёр хөршөөрөө ЦЗБ-ийн асуудлаар баталгаа гаргуулахыг чармайж байгаа улсын хувьд нэлээд ул суурьтай судлах асуудал болохыг анхаарах нь зүйтэй болов уу.

Хөрш орнуудын цөмийн хаягдлын асуудал Монгол улсын хилийн ойролцоо байгаа нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчны асуудал үүсгэж байхад бид бүр нутагтаа цөмийн шаарыг булшлах асуудал ярих нь хэр зохимжтой болохыг бодож үзэх хэрэгтэй асуудал юм. Үүний зэрэгцээ Үндэсний Аюулгүйн байдлын Зөвлөлийн зохих шийдвэргүйгээр цөмийн хаягдлын асуудлаар аль нэг улс орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, Монгол улсын нэрийн өмнөөс аливаа яриа хэлэлцээр хийх, гэрээ хэлцэл байгуулах, баримт бичиг үйлдэх ч хууль эрх зүйн хувьд хаалттай³⁸. Монгол улсын ерөнхий сайд асан С.Батболд 2012 оны 3 сард Японд айлчлах үедээ "Цөмийн хаягдлыг хадгалах гэж байгаа гэдэг яриа бол сенсаци. Монгол Улсын Засгийн газар цөмийн хаягдлыг булшилах асуудлаар хэзээ ч ярьж байгаагүй. Цаашид ч ярихгүй. Энхийн зорилгоор цөмийн эрчим хүчийг ашиглах асуудал байх ёстой. Энэ талаар бодлогын түвшинд яригдаж байгаа болно"³⁹ гэсэн мэдэгдэл хийж "Мөн АНУ-ын Нью Йорк хотод болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 66 дугаар чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож "Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн хог хаягдлыг байршуулах асуудал байхгүй гэдгийг онцлон тэмдэглэсэн"⁴⁰.

Ийнхүү Ерөнхий сайд Японд айлчилж, Монголд эсэргүүцлийн жагсаал үргэлжилж байхад буюу гуравдугаар сарын 13-нд Японы "Майничи" сонинд нэгэн нийтлэл хэвлэгдсэн юм. Тус нийтлэлд АНУ болон Япон Монголд Атомын цахилгаан станц барих нэрийдлээр цөмийн хаягдал булшлах гэж буйг илчилжээ⁴¹. Хэдийгээр тухайн үед албан ёсны мэдээлэл гарч байсан ч гэсэн Японы "Майничи" гэх мэт өдөр тутмын сонингуудад 2011 оны 4 сарын 9-нд тус сонины сурвалжлагч Америкийн цөмийн мэргэжилтэнтэй Монголд цөмийн хаягдал булшлах гэж буй талаар ярилцахад АНУ-ын Эрчим хүчний яам, Японы Худалдаа аж үйлдвэрийн яам Монголын талтай энэ талаар нууцаар ярилцсан⁴² хэмээн тус сонины сурвалжлагч Харуюки Айкава бичсэн байна.

³⁷ http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=206:2012-06-15-03-10-47&catid=1:latest-news

³⁸ http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=206:2012-06-15-03-10-47&catid=1:latest-news

³⁹ http://www.inet.mn/?vfile=5&vmet_id=50048&vmet_main=6509&vt=archive&vl=archive&vdate=&vofile=5&left=yes&vpage=3

⁴⁰ http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=206:2012-06-15-03-10-47&catid=1:latest-news

⁴¹ http://ulstur.zaluu.com/index_med.php?id=855

⁴² <http://mainichi.jp/english/english/perspectives/news/20120313p2a00m0na003000c.html>

Дээр аюултай хог хаягдалд хяналт тавих тухай хуулийг дурдсан. Түүнээс гадна энэ асуудалд хамгийн их хамаатай, манай цөмийн зэвсэггүй бүсийн бодлогыг баталгаажуулсан “Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль” гэж бий. Энд цөмийн хог хаягдлыг булшлах, нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлэхийг хориглосон маш тодорхой заалтууд бий. Дээр хэлсэн манай улсын цөмийн зэвсгээс ангид байх бодлого нэгэнт олон улсын анхааралд орсон бодлого, дээр нь үндэсний аюулгүй байдал, эрх ашгийг шууд хөндсөн маш том асуудал⁴³ юм.

⁴³ <http://www.president.mn/mongolian/node/2085>